

Огноо: 2024.02.19

№ 10

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Банкны тухай хуулийн 35.3 дугаар зүйл, Төрийн банк ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.7 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг Төрийн Банк ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Төрийн банк” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Банкны 2023 оны санхүүгийн тайлангаарх /аудитлагдаагүй/ татварын дараах цэвэр ашгаас нийт эргэлтэд байгаа 755,096,250 ширхэг хувьцаанд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
3. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн дүнг 66.20 /жаран зургаан төгрөг хорин мөнгө/ төгрөг байхаар тогтоосугай.
4. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
5. Ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар дамжуулан эрх бүхий этгээдийн зөвшөөрөл шийдвэр ирснээс хойш 60 хоногийн дотор олгохыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.
6. Ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.
7. Энэ тогтоолын хувийг Монголбанканд хүргүүлж ногдол ашиг хуваарилах зөвшөөрөл авах болон Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-д тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

8. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах болон ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга (Б.Тэлмүүн)-д үүрэг болгосугай.

9. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН